

# СТРАТЕГИЙН БРЭНДИЙН УДИРДЛАГА

АЛЕКСАНДР ЧЕРНЕВ

ХОЁР ДАХЬ ХЭВЛЭЛ

# СТРАТЕГИЙН БРЭНДИЙН УДИРДЛАГА

АЛЕКСАНДР ЧЕРНЕВ

Келлогийн нэрэмжит менежментийн сургууль  
Нортвестернийн их сургууль

ХОЁР ДАХЬ ХЭВЛЭЛ

## ХОЁР ДАХЬ ХЭВЛЭЛ

Энэхүү номын аль ч хэсгийг эрхлэн хэвлэгч Cerebellum Press, Inc компаниас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр, АНУ-ын Зохиогчийн эрхийн тухай хуулийн 107, 108 дахь хэсэгт зөвшөөрөгдсөнөөс бусад арга хэлбэр буюу цахим, механик, фото хуулбар, бичлэг, зургийн хуулбар зэргээр бичлэг хийх, хуулах, хадгалах, дамжуулахыг хориглоно. Зохиогчийн эрхийн зөвшөөрлийн талаар холбогдохыг хүсвэл Cerebellum Press, Inc компанийн sales@cerebellum-press.com хаягаар хандана уу. Монгол орчуулгын эрхийг Аксиом Инк ХХК эзэмших бөгөөд та бүхэн info@axiominc.mn хаягаар хандана уу.

Номонд ашиглагдсан бүх худалдааны тэмдэг болон нэрс нь тухайн эзэмшигчийн өмч мөн. Эрхлэн хэвлэгч болон зохиогч энэхүү номыг бүтээхэд бүхнээ дайчилж, сайн бүтээл гаргахыг хичээсэн ч уг номын агуулга бүрэн гүйцэд, туйлын зөв гэсэн баталгаа өгөхгүй болно.

Номын агуулгад багтсан зөвлөгөө, стратегиуд нь тухайн нөхцөл байдалд тохирохгүй байж болох бөгөөд шаардлагатай тохиолдолд та мэргэжлийн хүнтэй зөвлөлдөнө үү. Номонд тусгагдсан санаануудаас болж ашиг орлого буурах, худалдааны нэр хүндээ алдах гэх мэт хохирсон асуудалд эрхлэн хэвлэгч болон зохиогч аль аль нь хариуцлага хүлээхгүй болно.

Стратегийн брэндийн удирдлага

Хоёр дахь хэвлэл 2017 оны 10 сар

ISBN: 978-1-936572-35-9 (Зөөлөн хавтастай)

Зохиогчийн эрх ©2015-2017 Александр Чернев

www.chernev.com

Эрхлэн хэвлүүлэгч: Cerebellum Press, USA

Mongolian translation right @2021 Axiom Inc LLC. This translation is published under the license with the original publisher Cerebellum Press.

Монгол орчуулгын эрх ©2021 Аксиом Инк ХХК

**Александр Чернев: Стратегийн брэндийн удирдлага**

Хоёр дахь хэвлэл

Англи хэлнээс орчуулсан:

Г.Үүрдмандах

Хянан тохиолдуулсан:

Б.Нандин-Эрдэнэ

Ц.Булган

С.Сайн-Од

Э.Долгор

Хяналтын уншлага:

Т.Алтангэрэл

И.Батбаяр

Ч.Буянжаргал

Хүснэгт, график бэлтгэсэн:

О.Алтанцаг

Индекс, нэрс шивсэн:

Б.Хос-Уянга

Эх бэлтгэгч:

Б.Эрдэнэцогт



Имэйл: info@axiominc.mn

Утас: 976-75111111

## АГУУЛГА

|                          |                                                    |            |
|--------------------------|----------------------------------------------------|------------|
| ОРШИЛ                    |                                                    | vii        |
| <b>НЭГДҮГЭЭР ХЭСЭГ</b>   | <b>ЕРӨНХИЙ ТОЙМ</b>                                | <b>9</b>   |
| Нэгдүгээр бүлэг          | Маркетингийн стратеги ба тактик                    | 13         |
| Хоёрдугаар бүлэг         | Брэнд зах зээлийн үнэ цэн бүтээх хэрэгсэл болох нь | 25         |
| <b>ХОЁРДУГААР ХЭСЭГ</b>  | <b>ХҮЧИРХЭГ БРЭНД БҮТЭЭХ НЬ</b>                    | <b>35</b>  |
| Гуравдугаар бүлэг        | Брэндийн стратеги боловсруулах нь                  | 39         |
| Дөрөвдүгээр бүлэг        | Брэндийн тактик зохиох нь                          | 63         |
| <b>ГУРАВДУГААР ХЭСЭГ</b> | <b>БРЭНДИЙГ УДИРДАХ НЬ</b>                         | <b>89</b>  |
| Тавдугаар бүлэг          | Брэндийн багцаа удирдах нь                         | 93         |
| Зургаадугаар бүлэг       | Брэндийн динамикийг удирдах нь                     | 115        |
| Долоодугаар бүлэг        | Брэндээ хамгаалах нь                               | 135        |
| Наймдугаар бүлэг         | Брэндийн шинжилгээ ба төлөвлөлт                    | 155        |
| <b>ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ</b> | <b>БРЭНДИЙН НӨЛӨӨГ ХЭМЖИХ НЬ</b>                   | <b>171</b> |
| Есдүгээр бүлэг           | Брэндийн эквити ба хүч                             | 175        |
| Аравдугаар бүлэг         | Брэндийн судалгаа                                  | 185        |
| <b>ИНДЕКС</b>            |                                                    | <b>204</b> |



## ЗОХИОГЧИЙН ТУХАЙ

Александр Чернев бол Нортвестерн их сургуулийн Келлогийн нэрэмжит менежментийн сургуулийн маркетингийн профессор юм. Тэрээр сэтгэл судлалын шинжлэх ухааны докторын зэрэгтэй бөгөөд хоёр дахь докторын зэргээ Дюкийн их сургуульд хамгаалсан.

Доктор Чернев бизнесийн стратеги, брэндийн удирдлага, хэрэглэгчийн зан төлөв, маркетингийн төлөвлөлтийн чиглэлээр олон тооны өгүүлэл бичсэн. Түүний судалгаанууд маркетингийн мэргэжлийн тэргүүлэх сэтгүүлүүдээс гадна бизнест болон нийтэд зориулсан The Wall Street Journal, Financial Times, The New York Times, The Washington Post, Harvard Business Review, Scientific American, Associated Press, Forbes, Business Week зэрэг хэвлэлүүдэд нийтлэгдсэн. Түүнийг Journal of Marketing сэтгүүл маркетингийн шилдэг арван эрдэмтний нэгээр, Journal of Marketing Education сэтгүүл олон улсад маркетингийн багш нараас авсан судалгааны үр дүнд хэрэглэгчийн зан төлөв чиглэлээр шилдэг таван судлаачийн нэгээр зарласан байдаг.

Доктор Черневийн “Стратегийн маркетингийн удирдлага”, “Стратегийн брэндийн удирдлага”, “Маркетингийн төлөвлөгөө боловсруулах гарын авлага”, “Бизнес Модель: Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, зах зээлийн үнэ цэн үүсгэх, өрсөлдөөнийг үл тоомсорлох аргагүй” зэрэг номууд нь олон хэлээр орчуулагдан гарсан бөгөөд дэлхий даяар бизнесийн шилдэг сургуулиуд, маркетингийн мэргэжилтнүүд ашигладаг. Түүнчлэн Journal of Marketing сэтгүүлийн ерөнхий эрхлэгч төдийгүй Journal of Marketing Research, Journal of Consumer Research, Journal of Consumer Psychology, Journal of the Academy of Marketing Science, Journal of Marketing Behavior зэрэг тэргүүлэх сэтгүүлүүдийн эрхлэгчдийн зөвлөлд ажилладаг.

Доктор Чернев нь Келлогийн нэрэмжит менежментийн сургуулийн магистр, докторын хөтөлбөр, удирдах ажилтнуудыг хөгжүүлэх хөтөлбөрт маркетингийн стратеги, брэндийн удирдлага, зан төлөвийн шийдвэр гаргалтын онол зэрэг хичээлүүдийг заадаг. Мөн Франц, Сингапурт байрладаг INSEAD, Швейцарын IMD, Хонг Конгын Шинжлэх ухаан, технологийн их сургууль зэрэг их сургуулиудын хэрэгжүүлдэг удирдах ажилтнуудыг хөгжүүлэх хөтөлбөрт хичээл заадаг. Доктор Чернев “Захирлын нэрэмжит суурь хичээлийн шилдэг багш”, “Келлогийн хамгийн нөлөө бүхий багш” зэрэг шагнал авснаас “Келлогийн удирдах ажилтнуудыг хөгжүүлэх магистрын хөтөлбөрийн шилдэг багш” цолыг есөн удаа хүртсэн.

Доктор Чернев багшлах, судалгаа хийхээс гадна Marketing Science Institute-ийн Эрдмийн зөвлөлд ажилладаг бөгөөд дэлхий даяар компаниудад маркетингийн стратеги, брэндийн удирдлага, хэрэглэгчийн зан үйл, үнэ тогтоох аргагүй, стратеги төлөвлөлт, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх чиглэлээр зөвлөгөө өгдөг. Тэрээр Fortune 500-ийн компаниудад бизнесийн моделио өөрчлөх, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, өрсөлдөөний давуу тал олж авахад нь тусалж ажилладаг. Тэрээр эхэн үедээ яваа гарааны компаниудад хөрөнгө оруулалт хийдэг бөгөөд гарааны олон компаниудад зах зээлийн шинэ боломжийг олж ашиглах, бизнес моделио боловсруулах, зах зээлд гарах стратегиа хэрэгжүүлэхэд нь тусалсан.

## ТАЛАРХАЛ

Энэхүү ном Нортвестерн их сургуулийн Келлогийн нэрэмжит менежментийн сургуульд одоо ажиллаж буй болон өмнө нь ажиллаж байсан олон хүмүүс тухайлбал: Эрик Андерсон, Жим Андерсон, Ульф Бөкенхолт, Мигель Брэндл, Бобби Кальдер, Тим Калкинс, Грегори Карпентер, Моран Серф, Аннэ Коуглан, Келли Голдсмит, Кент Грэйсон, Жулли Хеннеси, Апарна Лабро, Лакшман Кришнамурти, Эрик Лейнингер, Анжела Ли, Сидней Леви, Михал Маймаран, Эяал Маоз, Блэйк МакШэйн, Кевин МакТиг, Мэри Перлман, Дерек Ракер, Брайн Стернталь, Рима Тур-Тиллери, Алис Тибуа, Сон Яао, Флориан Зеттельмейер зэрэг хамтран зүтгэгчдийн мэргэн ухааны үр шимийг шингээсэн.

Номын агуулгыг нягтлан, үнэлж баршгүй зөвлөгөө өгсөн Нийл Рөүз (Нортвестерн их сургууль), Райн Хамилтон (Эмори их сургууль) нарт гүн талархал илэрхийлье. Мөн брэндийн удирдлагын хуультай холбоотой асуудлуудаар зөвлөгөө өгсөн Жэймс Конли, Марк МакКарейнс нарт (Нортвестерн их сургууль) талархал илэрхийлье. Тоолж баршгүй олон брэндийн логонуудыг хянасан Файе Палмер болон номыг сайтар хянан тохиолдуулсан Жоанн Фрийман нарт талархал илэрхийлж байна.

Энэхүү номыг бичих урам зориг өгч, агуулга нь цогцлоход хувь нэмрээ оруулсан Келлогийн нэрэмжит сургуулийн магистр болон удирдах ажилтнуудад зориулсан магистрын хөтөлбөрийн оюутнууддаа онцгой талархал илэрхийлье.

Гүн гүнзгий ойлголт өгдөг бүтээлүүдээрээ маркетингийг сонирхох очийг бадраасан маркетингийн тэргүүлэх сэтгэгчдийн нэг Филип Котлерт баярлаж талархаж явдгаа илэрхийлье. Эрдэм шинжилгээний салбарт зам мөрөө олоход минь тусалж, зөвлөж ирсэн Дюкийн их сургуулийн Фукуагийн нэрэмжит бизнесийн сургуулийн Жим Беттман, Жули Эделл, Иоел Хубер, Жон Линч, Жон Пэйн, Рик Стэлин нарт гүн талархлаа илэрхийлье.

## ОРШИЛ

**Б**рэнд бол компанийн хамгийн үнэ цэнтэй хөрөнгүүдийн нэг юм. Apple, Coca-Cola, Disney, McDonald's, Nike зэрэг брэндүүд тус бүр нь хэдэн арван тэрбум доллароор үнэлэгддэг. Шилдэг 100 брэндийн нийт үнэлгээ нь их наяд доллароор хэмжигддэг. Эдгээр компаниудын хувьд брэндийн үнэ цэн нь биет хөрөнгүүдээсээ илүү байдаг. Брэндүүд нь шинэ баялаг бүтээгчид болсон.

Брэндүүд ийнхүү чухал болсон нь хэд хэдэн хүчин зүйлээс улбаатай байдаг. Сүүлийн хэдэн арван жилд аутсорсингийн урьд хожид байгаагүй шинэ давлагаа үүссэн нь нэг үйлдвэрлэгч хоорондоо өрсөлдөж буй компаниудад ижил бүтээгдэхүүнийг хийж нийлүүлэх буюу бүтээгдэхүүн таваарчлагдах үйл явцыг хурдасгасан. Бүтээгдэхүүн таваарчлагдах нь компаниудад тулгарч буй ганц асуудал биш юм. Технологийн инновацын улмаас бүтээгдэхүүний чанар эрс сайжирч, өрсөлдөгчдийн ихэнх нь хэрэглэгчдийн үндсэн хэрэгцээг хангасан бүтээгдэхүүн бий болгох боломжтой болсон. Бүтээгдэхүүн хүчин чадлын тодорхой түвшинд хүрч, “хангалттай сайн” болмогц хэрэглэгчид өрсөлдөгч бүтээгдэхүүнийг бараг л адилхан гэж үздэг. Жишээлбэл дэлгэцийн технологи сайжирч, нягтрал нь хүний нүдний чадвараас давмагц хэрэглэгчид хоорондоо өрсөлдөж буй дэлгэцүүдийн ялгааг тоохоо больдог. Компани бүтээгдэхүүнүүдийг үндсэн хүчин чадлаар өрсөлдөгчдөөсөө ялгарах чадвар нь буурснаар брэндээр ялгарахаас өөр аргагүй болдог. Бүтээгдэхүүн, үйлчилгээ хурдан таваарчлагдах болсон өдгөө цагт брэнд өрсөлдөөнд ялгарах шинэ талбар болж байна.

Энэ чиглэлээр амжилт олохын тулд брэнд зах зээлийн үнэ цэн бүтээх ёстой. Брэндийн үнэ цэн бүтээх загвар нь стратеги, тактик гэсэн хоёр үндсэн бүрэлдэхүүнтэй. Брэндийн удирдлагын стратегийн бүрэлдэхүүн гэдэг нь брэндийн өрсөлдөх зорилтот зах зээлийг илрүүлэх, тухайн зах зээлд брэндийн бүтээх үнэ цэнийг тодорхойлох явдал байдаг. Харин брэндийн тактик гэдэг нь брэндийг бүтээх, брэндийн үнэ цэнийг зах зээлд оролцогч талуудад хүргэх, харилцах зэрэг тодорхой үйл ажиллагаануудтай холбогддог. Тиймээс брэндийн амжилт нь брэндийн стратегийн “амьдрах чадвар” болон тактикийн шийдвэрийн үр ашиг буюу зах зээлийн үнэ цэнийг бүтээж буй эсэхээр тодорхойлогдоно.

Зах зээлийн үнэ цэн бүтээж чадах брэндийн шийдвэр гаргах нь цогц, ярвигтай үйл явц. Тиймээс компаниудад брэнд бүтээхдээ ашиглах, брэндийн удирдлагыг системтэй ойлгоход туслах онолын загварууд хэрэгтэй. Энэ номд брэндийн удирдлагын эдгээр онолын загваруудыг багтаасан. Брэндийн удирдлагын эдгээр загварууд нь Маркетингийн удирдлагын ерөнхий загвараас улбаалж гарсан. Маркетингийн удирдлагын ерөнхий загварт брэндээс гадна компанийн санал болгодог бусад зүйлс буюу бүтээгдэхүүн, үйлчилгээ, үнэ, урамшуулал, сурталчилгаа, түгээлт зэргийг хэрхэн удирдах талаар тусгадаг. Брэндийн тактик нь маркетингийн бусад тактикуудтай хоршиж хэрэглэгч, хамтрагч зэрэг оролцогч талуудын ой тойнд компанийн дүр төрхийг зөвөөр бүтээх, зах зээлийн үнэ цэнийг бий болгоход чиглэдэг.

Энэхүү номд стратегийн брэндийн удирдлагын онолыг дараах байдлаар өгүүлнэ. Бүлэг 1-д брэндийн удирдлага цөм нь болдог маркетингийн удирдлагын онолын ерөнхий загварыг танилцуулна. Бүлэг 2-т зах зээлийн үнэ цэн бүтээхэд брэндийн гүйцэтгэдэг онцгой үүргийг тайлбарлаж, брэндийн удирдлагын онолын загварыг тоймлон харуулна. Бүлэг 3-т брэндийн стратеги бүтээх гол талбарууд буюу зорилтот зах зээл, зорилтот хэрэглэгчдэд өгөх брэндийн үнэ цэнийг саналыг тодорхойлох арга замуудыг авч үзнэ. Бүлэг 4-т брэндийн тактик буюу зах зээлийн үнэ цэнийг бүтээх, хэрэглэгчдэд хүргэх арга замуудыг авч үзнэ. Бүлэг 5-д брэндийн багцаа удирдах, брэндийг хамтран бүтээх стратегиудыг авч үзнэ. Бүлэг 6-д брэндийг өөрчлөн хоногшуулах, өргөжүүлэх гэх мэт урт хугацаанд удирдахтай холбоотой асуудлуудыг авч үзнэ.

---

<sup>1</sup> Таваарчлагдах - Commoditization - Бүтээгдэхүүн таваар болох буюу өөр хоорондоо шинж чанараараа ялгагдахгүй болох үйл явц.



Бүлэг 7-д брэндээ хамгаалах хууль зүйн асуудлуудыг онцолж, брэндийн удирдлагын хууль эрхзүйн ойлголтуудыг тоймлон авч үзнэ. Бүлэг 8-д брэндийг удирдах, хэрэгжихүйц төлөвлөгөө боловсруулах асуудлыг ярилцана. Бүлэг 9-д брэндийн үнэлгээтэй холбоотой асуудлуудыг авч үзнэ. Хамгийн сүүлд буюу Бүлэг 10-д брэндийн судалгааны түгээмэл аргуудыг авч үзнэ.

Нэгдүгээр Хэсэг:

## Ерөнхийн тойм



## УДИРТГАЛ

*Бүтэлгүйтэх мянган арга байдаг ч амжилтад хүрэх ганц арга байдаг.*  
- Аристотель, Грекийн гүн ухаантан

**Б**рэндийн удирдлага нь маркетингийн удирдлага хэмээх үргэлжилсэн үйл явцын нэг хэсэг учир брэндийн болон маркетингийн удирдлагад нийтлэг зарчим, онолууд яригддаг. Тиймээс энэхүү номын эхний бүлэгт маркетингийн удирдлагыг зах зээлийн үнэ цэн бүтээх системтэй, дараалалтай үйл явц гэдэг утгаар тоймлон харуулав. Энэ бүлэгт брэнд бол хэрэглэгчид, компани, хамтрагч байгууллагуудад үнэ цэнийг бүтээх зориулалттай бизнесийн хэрэгсэл юм гэдгийг дүрслэн үзүүлсэн. Номын эхний бүлэг хоёр хэсгээс бүрдэнэ.

Үүнд:

**Бүлэг 1-д** маркетингийн удирдлагын онолыг тоймлож, компанийн бизнес моделийн стратеги, тактик гэсэн хоёр гол бүрэлдэхүүнийг онцолно. Маркетингийн стратеги нь компанийн ажиллах зах зээлийг тодорхойлж, тухайн зах зээл дэх этгээдүүдэд ямар үнэ цэн санал болгохыг тоймлодог. Тактик нь компанийн стратегийг хэрэгжүүлэх арга зам буюу маркетингийн саналыг боловсруулах, түүгээрээ харилцах, хүргэх байдлаар зах зээлийн үнэ цэнийг бүтээх тодорхой үйл ажиллагаанууд юм.

**Бүлэг 2-т** маркетинг бол үнэ цэн бүтээх үйл явц гэсэн үзэл баримтлалд тулгуурлаж, зах зээлийн үнэ цэн бүтээхэд брэндийн гүйцэтгэдэг онцгой үүргийг дүрслэн үзүүлсэн. Үргэлжлүүлээд энэ хэсэгт үнэ цэн бүтээх моделийн гол бүрэлдэхүүн болдог брэндийн стратеги, тактикийг тодорхойлно. Брэнд хэрэглэгчид, компани, хамтрагч байгууллагуудад өгдөг үнэ цэнийг тоймлох замаар брэндийн удирдлагын онолын ерөнхий бүдүүвчийг үзүүлнэ.

Энэ хоёр бүлэг номын үлдсэн хэсэгт брэндийн удирдлагын талаар илүү нарийвчилсан асуудлуудыг авч үзэх суурь болно



# МАРКЕТИНГИЙН СТРАТЕГИ БА ТАКТИК

*Тактикгүй стратеги бол ялалтад хүрэх хамгийн удаан арга юм.  
Стратегигүй тактик бол мөхлийн өмнөх чимээ.*

- Сүнз, Хятадын цэргийн стратегич

**Б**рэндийн удирдлага нь маркетингийн удирдлага хэмээх том үйл явцын нэг хэсэг тул маркетингийн удирдлагад баримталдаг ерөнхий зарчим, онолууд нь брэндийн удирдлагад ч хүчинтэй байдаг. Компанийн том зорилгын хүрээнд маркетингийн бусад үйлдлүүдтэй хоршиж байж л хүчтэй брэнд бүтээх брэндийн удирдлагыг амжилттай хэрэгжүүлэх боломжтой. Тиймээс энэ бүлгийн зорилго брэндийн удирдлагад хамааралтай маркетингийн гол онол, ойлголтуудыг танилцуулахад оршино<sup>1</sup>.

## Маркетинг Үнэ цэн бүтээх Үйл явц болох нь

Маркетинг бол зах зээлийг ойлгох, бүтээх, удирдахад чиглэсэн бизнесийн ухаан юм. Зах зээлд амжилт олох эсэх нь тухайн компани зах зээлийн оролцогч нарт зориулан үнэ цэн бүтээж чадаж байгаа эсэхээс хамаардаг. Учир нь үнэ цэн бүтээх тухай асуудал нь маркетингийн нэн тэргүүний бөгөөд хамгийн чухал зарчим. Зах зээлийн үнэ цэн бүтээх нь менежерийн шийдвэр гаргалтын баримжаа болдог гол зарчим бөгөөд маркетингийн бүх үйл ажиллагааны үндэс болдог.

Компани зах зээлийн үнэ цэн бүтээж буй арга зам нь зах зээлд үнэ цэнийг хүргэх, хүртэхтэй холбоотой этгээдүүд, хүчин зүйлс, үйл явцуудыг тодорхойлсон бизнес моделиос нь харагддаг. Бизнес модель нь үнэ цэн бүтээх үйл явцын гол цөмийг тодорхойлдог учир ажиллах чадвартай, тогтвортой бизнес модель зохиох нь зах зээлд амжилт олох гол түлхүүр байдаг.

Компанийн бизнес модель нь стратеги, тактик гэсэн хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй байдаг. Стратеги нь компанийн үйл ажиллагаа явуулах зорилтот зах зээлийг тодорхойлж, зах зээлийн солилцоонд холбогдох талуудад санал болгох үнэ цэний амлалтыг тоймлон гаргадаг. Харин тактик нь стратегийг хэрэгжүүлэхийн тулд маркетингийн хольц гэгддэг, зах зээлд амлах тодорхой саналуудыг боловсруулах, сурталчлах, хүргэх цогц үйл ажиллагаанууд юм. Стратеги нь зорилтот зах зээл, зах зээл дэх холбогдох этгээдүүдийн хооронд явагдах үнэ цэний солилцоог тодорхойлдог бол тактик нь тухайн саналын зах зээлийн үнэ цэн бүтээх талыг нь тодорхойлдог.

Маркетингийн стратеги, тактик дангаараа оршдоггүй. Эдгээр нь компанийн зорилго, тухайн зорилгодоо хүрэх арга замуудыг харуулсан маркетингийн төлөвлөгөөний үндсэн бүрэлдэхүүн хэсэг болдог. Маркетингийн төлөвлөгөөний үндсэн суурь нь компанийн зорилго, зорилгодоо хүрэхийн тулд хийх үйлдлүүдийг харуулсан үйл ажиллагааны төлөвлөгөө байдаг. Ийм үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа зорилго тавих, стратеги боловсруулах, тактик зохиох, хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулах, үйлдэл үр дүндээ хүрсэн эсэхийг хянах хэмжүүрүүд тогтоох гэсэн таван үйлдлийг хийдэг.

Компанийн бизнес моделийн хоёр бүрэлдэхүүн хэсэг болох стратеги ба тактик мөн бизнес моделийг бодит байдалд хэрэгжүүлэх үйл ажиллагаа боловсруулах асуудлыг бид дараагийн хэсэгт нарийвчлан ярилцана.

## Маркетингийн стратеги

Маркетингийн стратеги бол компани зах зээлийн үнэ цэн бүтээх зураг төсөл юм. Энэ нь зорилтот зах зээл, үнэ цэний амлалт гэсэн хоёр зүйлээс бүрддэг.

### Зорилтот зах зээлээ тодорхойлох нь

Компанийн өрсөлдөж буй зах зээл таван хүчин зүйлээр тодорхойлогддог. Үүнд: Хэрэглэгчид (*customers*) буюу компанийн санал<sup>ii</sup> нь тэдний хэрэгцээг хангахыг зорьж буй, саналаа удирдан зохицуулж буй компани (*company*), энэхүү саналд тухайн компанитай ажиллаж буй хамтрагчид (*collaborators*), хэрэглэгчдийг нь онилж өрсөлдөх санал хүргэж буй өрсөлдөгчид (*competitors*), компанийн ажиллаж буй эдийн засаг, технологи, нийгэм-соёл, эрхзүйн болон орчин нөхцөл (*context*) зэрэг болно. Эдгээр таван хүчин зүйлийг 5 Си гэдэг бөгөөд үүнээс үүдэлтэйгээр 5 Си загвар гэж хэлдэг. Үүнд:

- **Зорилтот хэрэглэгчид** (*target customers*) гэдэг нь компани саналаараа хангахыг хүсэж буй хэрэгцээ бүхий боломжит худалдан авагчид юм. Зорилтот хэрэглэгчид нь хувь хэрэглэгч (бизнесээс хувь хэрэглэгчид чиглэсэн зах зээл) ба/буюу бизнесүүд (бизнесээс бизнест чиглэсэн зах зээл) байж болдог.
- **Компани** (*company*) бол саналыг удирддаг байгууллага юм. Олон өөр саналуудаас бүрдсэн багцтай байгууллагуудын хувьд компани гэдэг нь тухайн байгууллагын аль нэг бизнес нэгж байдаг бөгөөд саналыг удирдаж буй бизнесийн стратегийн нэгж гэгддэг. Компани тухайн зах зээлд амжилттай өрсөлдөх чадвартай юу үгүй юу гэдэг нь зорилтот хэрэглэгчдийн хэрэгцээг хангахад туслах нөөц сурвалж буюу цөм чадвар, стратегийн хөрөнгөтэй эсэхээр тодорхойлогддог.
- **Хамтрагчид** (*collobrators*) гэдэг нь тухайн компани зорилтот хэрэглэгчдэд үнэ цэнийг бүтээхэд хамтран ажиллаж буй этгээдүүдийг хэлдэг. Ханган нийлүүлэгчид, үйлдвэрлэгчид, түгээгчид (дилерүүд, бөөний худалдаачид, жижиглэнгийн худалдаачид гм), судалгаа хөгжлийн этгээдүүд, үйлчилгээ үзүүлэгчид, гаднын ажиллах хүн хүч, сурталчилгааны агентлагууд, маркетингийн судалгааны байгууллагууд зэрэг нь үүнд багтдаг.
- **Өрсөлдөгчид** (*competitors*) гэдэг нь нэгэн ижил хэрэглэгчдийг онилж, тэдний хэрэгцээг хангахад чиглэсэн санал хүргэж буй этгээдүүд юм. Өрсөлдөөн тухайн компанийн ажиллаж буй салбараар хязгаарлагддаггүй. Нэг салбарынх биш атлаа ижил хэрэглэгчдийн хэрэгцээг хангахыг зорьж буй этгээдүүд өрсөлдөгчид багтдаг. Үүнээс шалтгаалан компанийн санал зөвхөн тухайн салбарт ажиллаж буй төдийгүй нэгэн ижил хэрэглэгчдийн хэрэгцээг хангахыг зорьж буй өөр салбаруудын саналуудтай (ихэвчлэн орлуулагчдыг авч үздэг) өрсөлдөх болдог.
- **Орчин нөхцөл** (*Context*) гэдэг нь компанийн ажиллаж буй орчны холбогдох гол талууд байдаг. Үнэ цэн бүтээх үйл явцад орчны таван хүчин зүйл ихээхэн нөлөөлдөг нь эдийн засгийн (эдийн засгийн өсөлт, мөнгөний нийлүүлэлт, инфляц, зээлийн хүүгийн түвшин), технологийн (өмнө гарсан технологийн тархалт, шинэ технологи гарч ирэх байдал), нийгэм-соёлын (хүн амзүйн тренд, үнэт зүйлийн

<sup>ii</sup>Offering- Санал- Компаниас зах зээлд санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нэршил

тогтолцоо, тухайн зах зээл дэх хүмүүсийн итгэл үнэмшил, зан үйл), эрхзүйн (импорт, экспортын тариф, татвар, бүтээгдэхүүний техникийн шаардлага, үнийн ба сурталчилгааны бодлого, патент, барааны тэмдгийн хамгаалалт), биет (байгалийн баялаг, уур амьсгал, хүн амын эрүүл мэнд) зэрэг болно.

Зорилтот хэрэглэгчдээ сонгох нь өрсөлдөөний цар, боломжит хамтрагчдын хүрээ, зорилтот хэрэглэгчдийн хэрэгцээг хангахад шаардлагатай компанийн цөм чадвар, хөрөнгө, зорилтот сегментэд л хамаарах орчны тодорхой хүчин зүйлс гэх мэт зорилтот зах зээлийн бусад талбаруудыг тодорхойлох ажлын суурь болдог. Яагаад гэвэл хэрэглэгчийн сегмент бүр нь компанийн бизнесийн өөр нэгжээр удирдуулах, өөр орчин нөхцөлд, өөр хамтрагчидтай ажиллах шаардлагыг үүсгэдэг. Зах зээлээ сонгоход зорилтот хэрэглэгчид гол суурь нь болдгийг Зураг 1-д харуулсан байна.

**Зураг 1. Зах зээлээ тодорхойлох нь: 5 Си загвар**



Зорилтот хэрэглэгчдээ өөрчлөх нь компани үнэ цэн бүтээж буй зах зээлийг тодорхойлж буй бусад хүчин зүйлс өөрчлөгдөхөд хүргэдгээрээ голлох үүрэгтэй байдаг. Жишээлбэл компани хэрэглэгчийн илүү өндөр түвшний сегментийг онилох шийдвэр гаргасан бол тэдгээр хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлдэг илүү өндөр түвшний жижиглэнгийн худалдаачидтай хамтран ажиллах, тухайн хэрэглэгчдэд амжилттай үйлчлэхийн тулд илүү мэргэшсэн цөм чадвар, стратегийн хөрөнгөтэй байх, тухайн хэрэглэгчдэд үйлчилж ирсэн шинэ төрлийн өрсөлдөгчидтэй өрсөлдөх, ажилладгаасаа эрс өөр орчин нөхцөлд ажиллах болдог.

### **Үнэ цэний амлалт боловсруулах нь**

Компанийн санал амжилтад хүрэхийн тулд зах зээлийн солилцоонд оролцож буй холбогдох гол этгээдүүд буюу зорилтот хэрэглэгчид, хамтрагчид, компанид бүгдэд нь дээд зэргийн үнэ цэн бүтээх ёстой. Үүнээс шалтгаалан компани зах зээлд зориулсан санал боловсруулахдаа *хэрэглэгчдэд өгөх үнэ цэн (customer value)*, *хамтрагчдад өгөх үнэ цэн (collobrators value)*, *компанид өгөх үнэ цэн (company value)* гэсэн гурван төрлийн үнэ цэнийг харгалзан үзэх хэрэгтэй болдог.

- **Хэрэглэгчдэд өгөх үнэ цэн** бол ямар нэг саналын хэрэглэгчид очиж буй үнэлэмж буюу хэрэглэгчид тухайн санал хэрэгцээг нь хэр зэрэг хангаж байна гэж үнэлж буй байдал юм. Тухайн санал хэрэглэгчид ямар үнэ цэн бүтээж өгч байна гэдэг нь (1) тухайн хэрэглэгчдийн хэрэгцээнүүд, (2) компанийн саналд төлж буй өртөг ба авч буй үр ашиг, (3) зорилтот хэрэглэгчид хэрэгцээгээ хангахын тулд хэрэглэж болох өөр хувилбаруудад (өрсөлдөгчдийн санал) төлөх өртөг ба авах үр ашиг зэргээр тодорхойлогддог. Энгийнээр хэлбэл хэрэглэгчдэд санал болгох



үнэ цэний амлалт *«Өөр хувилбарууд байхад зорилтот хэрэглэгчид яагаад тухайн компанийн саналыг сонгох ёстой вэ?»* гэсэн асуултад хариулах ёстой байдаг.

- **Хамтрагчдад өгөх үнэ цэн** нь тухайн компани хамтрагчдадаа өгч буй саналын үнэ цэн буюу хамтрагчдад очиж буй бүх үр ашиг болон өртөг зардлуудын нийлбэр юм. Хамтрагчдад өгөх үнэ цэн тухайн санал өрсөлдөгчдийн саналаас илүүтэйгээр хамтрагчдад тэдний зорилгодоо хүрэхэд нь туслах чадвартай эсэхээр тодорхойлогддог. Энгийнээр хэлбэл *«Өөр хувилбарууд байхад хамтрагчид яагаад тухайн компанийн саналыг сонгох ёстой вэ?»* гэсэн асуултад хариулах ёстой байдаг.
- **Компанид өгөх үнэ цэн** нь тухайн саналын компанид өгөх үнэ цэн байдаг бөгөөд саналтай холбоотой бүх үр ашиг, өртөг зардлуудын нийлбэр юм. Саналын үнэ цэн нь компанийн зорилготой хэр холбогдож буй байдал, өөр боломжуудын үнэ цэн, компани гаргаж болох өөр саналын үнэ цэн зэргээр тодорхойлогддог. Компанийн үнэ цэний амлалт *«Өөр хувилбарууд байхад компани яагаад энэ саналыг сонгох ёстой вэ?»* гэсэн асуултад хариулах ёстой байдаг.

Хэрэглэгчдэд, хамтрагчдад, компанидаа үнэ цэн бүтээх нь компанийн бүх үйлдлийг чиглүүлэх гол зарчим байдаг бөгөөд компанийн үнэ цэний амлалтыг зах зээлийн үнэ цэний зарчим буюу *«Санал тухайн компанид зорилгодоо хүрэхэд туслах байдлаар зорилтот хэрэглэгчид болон хамтрагчдад дээд зэргийн үнэ цэн өгөх ёстой»* гэсэн зарчмаар илэрхийлж болно.

Зах зээлийн үнэ цэний зарчим зорилтот хэрэглэгчид, компани, хамтрагчид гэсэн гурван гол этгээдэд зориулан үнэ цэн бүтээхийн чухлыг онцолдог учир үүнийг 3-V зарчим гэх нь бий. Зах зээлийн үнэ цэний зарчим бизнес модель амьдрах чадвартай эсэх нь дараах гурван багц асуултуудын хариултуудаар тодорхойлно. Үүнд:

*Тухайн санал зорилтот хэрэглэгчдэдээ яг ямар үнэ цэнийг өгөх вэ? Зорилтот хэрэглэгчид яагаад энэ саналыг сонгох ёстой вэ? Энэ санал бусад хувилбаруудаас юугаараа илүү вэ?*

*Тухайн санал компанийн хамтрагчдад яг ямар үнэ цэнийг өгөх вэ? Хамтрагчид гэгдэх этгээдүүд (ханган нийлүүлэгчид, түгээгчид, хамтран боловсруулагчид) яагаад тухайн компанид туншилэх ёстой вэ?*


*Тухайн санал компанид яг ямар үнэ цэн өгөх вэ? Компани яагаад бусад хувилбаруудад биш, энэ саналд хөрөнгө оруулах ёстой вэ?*

Гурван өөр оролцогч талуудад өгөх үнэ цэнийг удирдах нь хэнийх нь хэрэгцээг чухалчлах вэ гэсэн асуултад хүргэдэг. Гайхалтай нь компаниудын ихэнх нь энэ тал дээр нэгдмэл ойлголцолд хүрч чаддаггүй. Маркетингийнхан голдуу хэрэглэгчдэд өгөх үнэ цэнийг чухалчилдаг бол санхүүгийнхэн болон дээд удирдлагууд компанид өгөх үнэ цэнд, борлуулалтынхан дилерүүд, бөөний, жижиглэнгийн худалдаачид гэх мэт хамтрагчдад өгөх үнэ цэнийг чухалчилдаг.

«Зөв» хариулт бол компани үнэ цэний амлалтаа оновчтой байлгахын тулд оролцогч талууд, хэрэглэгчид, хамтран ажиллагчдынхаа дунд үнэ цэнд тэнцвэртэй хандах хэрэгтэй гэсэн хариулт юм. Үнэ цэн оновчтой байна гэдэг нь санал гурван талын аль алинд тэнцвэртэй буюу компанид стратегийн зорилгодоо хүрэх боломж олгохын зэрэгцээ зорилтот хэрэглэгчид, хамтрагчдад үнэ цэн бүтээхүйц байх ёстой. Хэрэглэгч, компани, хамтрагчдад өгөх үнэ цэнийг

оновчлох нь зах зээлд амжилт олох тулгын гурван чулуу болсон зах зээлийн үнэ цэний зарчим юм (Зураг 2). Энэ талуудын аль нэгэнд дээд зэргийн үнэ цэнийг өгч чадахгүй байх нь бизнес модель тогтворгүй байх, шинэ бизнесийг дампуурахад хүргэдэг.

**Зураг 2. Зах зээлийн үнэ цэний 3-V зарчим**



Үүнийг Starbucks компани зах зээлийн үнэ цэн бүтээдэг арга барилаар дүрслэн харуулж болох юм. Хэрэглэгчид янз бүрийн кофе сонгож хэрэгцээгээ хангах бодит үр ашиг авах төдийгүй зөвхөн өөртөө тохируулж хийсэн ундааг сонгож бие хүний онцлогоо илэрхийлэх сэтгэлзүйн үр ашиг авдаг. Starbucks-ын хамтрагчид буюу кофе тариалагчид кофены үрийг зарж мөнгө авахаас гадна бүтээгдэхүүн нь тогтвортой эрэлттэй байх стратегийн үр ашиг авч, түүнийхээ хариуд Starbucks-ын стандартад нийцсэн кофены шош ургуулахад хөрөнгө оруулалт хийдэг. Компани хэрэглэгчдэдээ зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээ боловсруулах, санал болгоход нөөцөө зарцуулж, хөрөнгө оруулалт хийснээр мөнгөн үр ашиг хүртэх төдийгүй эцсийн хэрэглэгчдэд зориулсан брэнд бүтээж, зах зээлд эзлэх хувь, саналын багцаа өргөжүүлэх стратегийн шинжтэй үр ашгийг хүртдэг.

Үнэ цэний амлалт нь компани саналаараа зах зээлийн гурван гол этгээдэд өгөх үнэ цэнийг тусган харуулдаг. Үнэ цэний амлалт нь зах зээл дээр биет байдлаар байдаггүй. Компани болон түүний хамтрагчид зорилтот хэрэглэгчдэд зориулан зохиож, харилцаа тогтоож, хүргэж буй тодорхой саналын үр дүнд үнэ цэн бүтээгддэг. Дараах хэсэгт зах зээлийн үнэ цэн бүтээх саналыг зохиох гол талбаруудыг авч үзнэ.


## **Маркетингийн тактикууд: Зах зээлийн саналыг зохиомжлох нь**

Зах зээлийн санал (market offering) гэдэг нь компани тодорхой нэг хэрэглэгчийн хэрэгцээг хангахын тулд гаргаж буй бодит бараа юм. Зах зээлийн санал нь компанийн стратегид хамааралтай зорилтот зах зээл болон үнэ цэний саналаас ялгаатай. Гол ялгаа нь зах зээлийн санал нь тактиктэй холбогдох бөгөөд тухай компани зах зээлдээ хэрхэн үнэ цэн бүтээх, өрсөлдөх, тодорхой арга замыг хэлдэг байна.

### **Зах зээлийн саналыг тодорхойлох онцлох долоон шинж**

Компанийн санал нь бүтээгдэхүүн (product), үйлчилгээ (service), брэнд (brand), үнэ (price), урамшуулал (incentives), харилцаа (communication), түгээлт (distribution) гэсэн долоон шинжээр тодорхойлогддог. Энэхүү долоон шинжийг маркетингийн хольц (marketing mix) гэдэг бөгөөд саналыг хүргэх стратегийг хэрэгжүүлэхдээ ашиглах тодорхой үйлдлүүдийн хослол юм. Саналыг тодорхойлж буй энэхүү долоон тактик бол менежерүүд зах зээлийн үнэ цэн бүтээхдээ ашиглах хэрэгслүүд юм (Зураг 3).

Зураг 3. Зах зээлийн саналыг тодорхойлох долоон шинж



Зах зээлийн саналыг тодорхойлдог онцлох долоон шинж нь дараах болно. Үүнд:

- **Бүтээгдэхүүн** (Product) гэдэг нь зорилтот хэрэглэгчдэд үнэ цэн бүтээхэд чиглэдэг бараа юм. Бүтээгдэхүүн нь биет (хоол хүнс, хувцас, автомашин гэх мэт) болон биет бус (программ хангамж, дуу хөгжим, видео гэх мэт) байж болдог. Бүтээгдэхүүн нь хэрэглэгчид барааг эзэмших эрх олгодог. Жишээлбэл машин юм уу компьютер худалдан авсан хэрэглэгч тэрхүү бүтээгдэхүүнийг өөрийн болгодог.
- **Үйлчилгээ** (Service) гэдэг нь хэрэглэгчид тухайн барааг (кино түрээслэх, гэр ахуйн барааг засах, эмнэлгийн үзлэг, татварын тайлан бэлдэх гэх мэт) эзэмших эрх олголгүйгээр үнэ цэн бүтээхэд чиглэдэг бараа юм. Нэг санал бараа болон үйлчилгээ аль аль нь байж болдог. Жишээлбэл программ хангамжийг худалдан авбал нэг хувийг эзэмших боломжтой болдог буюу бүтээгдэхүүн хэлбэрээр санал болгох, эсвэл үр ашгийг нь түр хүртэхийн тулд түрээсэлдэг үйлчилгээ хэлбэрээр хүргэж болдог.
- **Брэнд** (Brand) гэдэг нь компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бусдаас онцгой болгох, өрсөлдөгчдөөс ялгаруулах, саналын бүтээгдэхүүн болон үйлчилгээнээс давсан дахин давтагдашгүй үнэ цэнийг бүтээхэд чиглэдэг. Жишээлбэл Harley-Davidson брэнд өөрсдийн мотоциклын онцлогийг төлөөлөх бөгөөд Honda, Suzuki, Kawasaki, Yamaha зэрэг компаниудынхаас ялгаатайг илэрхийлдэг. Мөн тухайн брэндийг хэрэглэгчдийн л мэдрэх онцгой сэтгэл хөдлөлийг илэрхийлдэг.
- **Үнэ** (Price) гэдэг нь компани саналаа хүргэснээр түүний өгч буй үр ашгийн төлөө хэрэглэгчид, хамтрагчдаас авч буй мөнгөний хэмжээ юм.
- **Урамшуулал** (Incentives) гэдэг нь саналд зарцуулах зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх замаар үнэ цэнийг сайжруулах хэрэгсэл юм. Их хэмжээгээр худалдан авсны төлөө хөнгөлөлт үзүүлэх, үнэ бууруулах, купон, төлбөрийн тодорхой хэсгийг буцаан олгох, урамшуулал олгох, бонус олгох, уралдаан тэмцээн зохиох, шагнал өгөх зэрэг нь урамшууллын түгээмэл хэлбэрүүд юм. Хэрэглэгчдэд төдийгүй хамтрагч байгууллагуудад (сувгийн аль нэг хамтрагч гэх мэт) ч урамшуулал олгож болдог.


- **Харилцаа** (Communication) гэдэг нь зах зээлийн холбогдох этгээдүүд буюу зорилтот хэрэглэгчид, хамтрагчид, компани дотроо саналын тодорхой шинж чанаруудын талаар мэдээлэл хүргэх явдал юм.
- **Түгээлт** (Distribution) гэдэг нь саналыг зорилтот хэрэглэгчид болон хамтрагчдаа хүргэхэд ашиглаж буй сувгуудыг хэлдэг.

Дээрхийг зураглан үзүүлэхийн тулд Starbucks-ын зах зээлийн саналын онцлох шинжүүдийг авч үзье. Тэдний хувьд *бүтээгдэхүүн* гэдэг нь янз бүрийн кофе болон бусад шингэн хүнс, зарим төрлийн идэх зүйлс байдаг. *Үйлчилгээ* гэдэг нь хэрэглэгчдийн худалдан авалтаас өмнө, худалдан авах үед, худалдан авсны дараа үзүүлэх тусалцаа байдаг. *Брэнд* нь Starbucks-ын нэр, лого, хэрэглэгчийн ой тойнд бууж буй бусад холбогдох зүйлс байдаг. Үнэ нь Starbucks саналаа хэрэглэгчид өгөөд авч буй мөнгөний хэмжээ юм. Үнэнч хэрэглээг дэмжих хөтөлбөр, купон, түр хугацааны хямдрал зэрэг нь хэрэглэгчдэд илүү үр ашиг өгөхөд чиглэсэн хэрэгсэл буюу *урамшууллууд* юм. *Харилцаа* нь сурталчилгаа, нийгмийн сүлжээ, олон нийтийн харилцаа зэрэг янз бүрийн сувгуудаар Starbucks-ын талаар олон нийтэд хүргэж буй мэдээлэл юм. Starbucks-ын бүтээгдэхүүнийг зарах лицензтэй жижиглэнгийн сувгууд, өөрсдийн эзэмшлийн салбарууд нь хэрэглэгчид саналыг хүргэж буй *түгээлт* юм.

#### Маркетингийн тактикууд үнэ цэнийг зохиомжлох, харилцах, хүргэх үйл явц болох нь

Бүтээгдэхүүн, үйлчилгээ, брэнд, үнэ, урамшуулал, харилцаа, түгээлт гэсэн маркетингийн долоон тактикийг хэрэглэгчид өгөх үнэ цэнийг зохиомжлох (designing), харилцах (communicating), хүргэх (delivering) үйл явц гэж үзэж болох юм. Бүтээгдэхүүн, үйлчилгээ, брэнд, үнэ, урамшуулал зэрэг нь саналын үнэ цэнийг зохиомжлох талбаруудад багтах бол харилцаа нь үнэ цэнийг мэдээлэх үйл явц, түгээлт нь саналын үнэ цэнийг хүргэх талбарт багтана (Зураг 4). Хэрэглэгчид өгөх үнэ цэнийг энэ гурван талбарт бүтээх бөгөөд үнэ цэн бүтээх үйл явцад өөр өөр онцлох шинж чанартайгаар ялгаатай үүрэг гүйцэтгэнэ.

**Зураг 4. Маркетингийн тактикууд үнэ цэнийг зохиомжлох, харилцах, хүргэх үйл явц болох нь**



Бүтээгдэхүүн, үйлчилгээ, брэнд, үнэ, урамшуулал зэрэг нь гол зардал, үр ашгийг тодорхойлдог учир саналын үнэ цэний гол жолоодогч элементүүд болдог. Харилцаа болон түгээлт нь эхний таван элементүүдээр бүтээгдсэн үр ашгийг зорилтот хэрэглэгчдэд мэдээлэх, хүргэх сувгууд юм. Тиймээс харилцаагаар хэрэглэгчид бүтээгдэхүүн, үйлчилгээний ажиллагааны талаар мэдээлэл өгч, брэндийн дүр төрхийг бүтээж, үнийг нь олон нийтэд мэдүүлж, худалдан авагчдад борлуулалтын урамшууллын талаар мэдээлж, санал бэлэн

байгаа эсэхийг хэлдэг. Үүнтэй төстэйгөөр түгээлтээр компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэж, хэрэглэгчийн өгсөн төлбөрийг компанид авчирч, саналыг дагалдсан урамшууллыг хэрэглэгчид, хамтрагчдад хүргэдэг.

Үнэ цэн бүтээх үйл явцыг компанийн болон хэрэглэгчийн өнцгөөс харж болдог. Компанийн талаас бол үнэ цэн бүтээх нь үнэ цэнийг *зохиомжлох (designing)*, *харилцах (communicating)*, *хүргэх (delivering)* үйл явц байдаг. Хэрэглэгчийн талаас үнэ цэн бүтээх үйл явц нь саналын *анхаарал татах (attractiveness)*, *анхааралд өртөх (awareness)*, *бэлэн байх (availability)* байдал юм. Энэ үүднээс тухайн санал хэрэглэгчид өгөх үнэ цэн бүтээх чадвар нь дараах гурван асуултаар тодорхойлогддог. Үүнд:


*Тухайн санал юугаараа зорилтот хэрэглэгчдийн анхаарлыг татаж байгаа вэ?*

*Санал зорилтот хэрэглэгчдийн анхааралд хэрхэн өртөх вэ?*

*Зорилтот хэрэглэгчид саналыг хэрхэн өөрсдийн болгох вэ?*

Эхний асуултын хариулт саналын бүтээгдэхүүн, үйлчилгээ, брэнд, үнэ, урамшуулал зэрэгтэй холбоотой хэрэглэгчдийн гаргаж буй зардал, авч буй үр ашгийг тоймлон харуулдаг. Хоёр дахь асуултын хариулт компани саналынхаа тодорхой онцлогуудыг зорилтот хэрэглэгчдэд хэрхэн мэдээлэх арга замыг тоймлон харуулна. Гурав дахь асуултын хариулт нь компани саналыг зорилтот хэрэглэгчдээ зориулан бэлэн байлгахын тулд юу хийхийг харуулна. Энэ утгаараа саналын *анхаарал татах (attractiveness)*, *анхааралд өртөх (awareness)*, *бэлэн байх (availability)* шинжүүдийг удирдах хэрэглэгчдэд төвлөрсөн хандлага нь зорилтот хэрэглэгчдэд зориулан үнэ цэнийг *зохиомжлох (designing)*, *харилцах (communicating)*, *хүргэх (delivering)* буюу компанид төвлөрсөн хандлагыг иж бүрэн болгодог (Зураг 5).

**Зураг 5. Маркетингийн тактикууд: Компанийн үйлдлүүд ба хэрэглэгчид үзүүлэх нөлөө**



Үүнийг дүрслэн үзүүлэхийн тулд Starbucks-ын жишээн дээр үнэ цэнийг зохиомжлох, харилцах, хүргэх үйл явцыг авч үзье. Starbucks-ын саналын *бүтээгдэхүүн* гэсэн талбар нь бүтээгдэхүүний багцаа зохиомжлох буюу эспрессо, латтэ, махиатто, фрапучинонууд бүтээх, тэрхүү ундаануудын талаарх мэдээллийг хэрэглэгчдэд өгөх, биет байдлаар хүргэх зэргийг хамардаг. Тэдний саналын *үйлчилгээ* гэсэн талбар нь Starbucks хэрэглэгчдэдээ санал болгох үйлчилгээний түвшнийг тодорхойлох, үйлчилгээний бодлогоо (хэрэглэгчид хэдийд ч гайхалтай ундаа хүртэнэ гэх мэт амлалт) мэдээлэх, үйлчилгээгээ хэрэглэгчдэд эцсийн байдлаар хүргэх зэргийг хамардаг. Starbucks гэсэн *брэнд* бүтээнэ гэдэг нь брэндийн нэрээ зөв сонгох, лого зохиох, Starbucks брэнд нь хэрэглэгчдэд ямар утга учиртай (Starbucks-ын зорилго нь гэр, ажил хоёрын дараагаар хүмүүсийн “гурав дахь гэр” байх явдал байдаг) байхыг тодорхойлох зэргийг хамарна. *Үнийн* хувьд Starbucks уух юм болгоныхоо хэмжээ, хослолоос хамаарсан үнэ тогтоодог бөгөөд энэхүү үнээрээ хэрэглэгчидтэйгээ харилцаж (салбарууддаа үнийг бичиж байрлуулах гэх мэт), хэрэглэгчдийнхээ төлбөрийг салбарууддаа авдаг. Хамгийн сүүлд нь



Starbucks саналдаа ямар *урамшууллыг* (тодорхой төрөлд үзүүлэх хөнгөлөлт, нэгийн үнээр хоёрыг авах, үнэнч хэрэглэгчийг дэмжих хөтөлбөр гэх мэт), хэзээ, яаж үзүүлэх, хэрэглэгчдэд тэдгээрийг яаж мэдээлэх, зохих сувгуудыг (сонин, онлайн баннер, байршилд тулгуурласан гар утасны сурталчилгаа гэх мэт) ашиглан тэдгээрийг зорилтот хэрэглэгчдэд хэрхэн хүргэхээ шийддэг.

## Маркетингийн Удирдлагын G-STIC Загвар

Хэрэгжихүйц маркетингийн төлөвлөгөө боловсруулахад G-STIC загварыг ашигладаг бөгөөд энэ нь *зорилго* (*goal*) дэвшүүлэх, *стратег* (*strategy*) боловсруулах, *тактикуудаа* (*tactics*) зохиох, *хэрэгжүүлэлтийн* (*implementation*) төлөвлөгөө боловсруулах, хийх үйлдлүүдийн амжилтыг *хянах* (*control*) хэмжүүрүүдээ тогтоох гэсэн таван үйлдлээс бүрддэг. G-STIC (Goals-Strategy-Tactics-Implementation-Control) загвар нь хэрэгжүүлж болохуйц маркетингийн төлөвлөгөө боловсруулах маш ойлгомжтой бөгөөд хялбаршуулсан арга ашиглан стратегийн шинжилгээ, төлөвлөлт хийх аргаас улбаатай.

G-STIC загварын бүрэлдэхүүн хэсгүүдийг дараах байдлаар тоймлон тайлбарлаж болох юм. Үүнд:

